



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 1847

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Жаргалант сумын Бичигт, Тахилт, Наран, Рашаант, Алагтолгой, Буянт, Бугат багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн, гэрэлтүүлэг, камержуулалт" ажлын 2 дугаар багцын ажлыг гүйцэтгэгч "Баттод" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганданповрон – Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

|         |                 |   |
|---------|-----------------|---|
| Гишүүд: | Ц.Цогтбаяр      | – Жаргалант сумын Засаг даргын орлогч                   |
|         | Б.Бат-Оюун      | – Мэргэжлийн хяналтын газрын<br>Улсын байцаагч          |
|         | Л.Дорждээрэм    | – Хот тохижуулах газрын дарга                           |
|         | Д.Бямбасүрэн    | - Цагдаагийн газрын Шуурхай удирдлагын<br>тасгийн дарга |
|         | Б.Түмэндэмбэрэл | – Орон нутгийн өмчийн газрын<br>мэргэжилтэн             |

Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбат – Газрын харилцаа, барилга хот байгуулалтын  
газрын инженерийн дэд бүтцийн асуудал  
хариуцсан мэргэжилтэн

2. "Жаргалант сумын Бичигт, Тахилт, Наран, Рашаант, Алагтолгой, Буянт, Бугат багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайн, гэрэлтуулэг, камержуулалт ажлын 2 дугаар багцын ажлыг гүйцэтгэгч "Баттод" ХХК-ний ажлыг ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргаж хүлээн авахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ  Т.ЖАРГАЛСАЙХАН

Т.Жаргалсайхан